



СЭЛЭНГЭ АЙМГИЙН

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2022 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 32-01/29

Сүхбаатар сум

**ЦАГААННУУР СУМЫН 2-Р ЦЭЦЭРЛЭГИЙН  
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ТУХАЙ**

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан  
байгууллагын мэдээлэл**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Албаны даргын баталсан 32-01/33 тоот удирдамжаар Цагааннуур сумын 2-р цэцэрлэгт Монгол улсын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, хөрөнгө оруулалт, санхүүгийн мэдээллийг шалган дүгнэлт, зөвлөмж гаргах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, санхүүгийн сахилгыг мөрдүүлэх зорилготой.

Санхүүгийн хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга, улсын ахлах байцаагч Б.Дарихжав ахлаж, санхүүгийн хяналт шалгалтын мэргэжилтэн, дотоод аудитор Х.Оюунчимэг нар 2022 оны 08-р сарын 10-наас ажлын 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Шалгалтад 2-р цэцэрлэгийн 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн баримтууд, үйл ажиллагааны тайлантай холбоотой баримт материалыг хамруулав.

Цагааннуур сумын 2-р цэцэрлэг нь 2020 оны 1-р сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд улсын бүртгэлийн 3763013 тоот регистртэй, Төрийн банкны 100130715202, нэмэлт санхүүжилтийн 100130715403 тоот данс болон санхүүгийн баримтад 1-р гарын үсгийг 2-р цэцэрлэгийн эрхлэгч З.Сэлэнгэ, 2-р гарын үсгийг няглан бодогч О.Орхончимэг нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн байна. Нярав эд хариуцагчаар Б.Нямсүрэн ажиллаж байна.

2020-2021 оны хичээлийн жилд "Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллая" зорилготойгоор удирдах 1, гүйцэтгэх 9, үйлчлэх 19 нийт 30 ажиллагсадтай үйл ажиллагаагаа дунджаар 144 сурагчтайгаар явуулдаг байна.

Шилэн дансанд бүртгүүлэх хүсэлтийг тус байгууллагад ирүүлсний дагуу 2020 оны 03 дугаар сард эрхийг нээж өгсний дагуу төсөв санхүүгийн мэдээллээ байршуулж ил тод мэдээлэх болсон.

**Хоёр: Санхүү, төсвийн талаар**

Батлагдсан төсөв, гүйцэтгэлд 2020, 2021 оны жилээр дүн шинжилгээ хийлээ:

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 он			2021 он		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	хэмнэлт/+/ хэтрэлт /-/
1	Тусгай зориулалтын шилжүүлэг	352,834.4	352,834.4	0.0	390,605.0	390,605.0	0.0
2	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,296.6	28,419.6	7,877.0	37,762.9	26,303.6	11,459.3
3	нэмэлт санхүүжилт	0.0	0.0	0.0		297.6	-297.6
	<b>ОРЛОГЫН ДҮН</b>	<b>389,131.0</b>	<b>381,254.0</b>	<b>7,877.0</b>	<b>428,367.9</b>	<b>417,206.2</b>	<b>11,161.7</b>
1	Үндсэн цалин	172,563.7	174,678.2	-2,114.5	209,147.9	187,849.2	21,298.7
2	Нэмэгдэл	55,881.5	45,187.7	10,693.8	50,802.1	81,441.3	-30,639.2
3	Урамшуулал	20,430.6	20,430.6	0.0	20,357.7	20,357.7	0.0
4	Гэрээт ажлын хөлс	0.0	0.0	0.0	18,000.0	4,190.9	13,809.1
4	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын дүн</b>	<b>248,875.8</b>	<b>240,296.5</b>	<b>8,579.3</b>	<b>298,307.7</b>	<b>293,839.1</b>	<b>4,468.6</b>
5	Ажил олгогчоос төлөх НД-ын шимтгэл	33,598.2	30,711.4	2,886.8	39,820.2	39,615.1	205.1
6	Гэрэл, цахилгаан	1,043.6	4,816.3	-3,772.7	11,900.0	4,748.6	7,151.4
7	Түлш, халаалт	33,431.0	20,292.6	13,138.4	14,945.9	11,055.7	3,890.2
8	Цэвэр, бохир ус	822.0	3,310.6	-2,488.6	7,740.0	7,322.3	417.8
9	<b>Тогтмол зардлын дүн</b>	<b>35,296.6</b>	<b>28,419.6</b>	<b>6,877.1</b>	<b>34,585.9</b>	<b>23,126.6</b>	<b>11,459.3</b>
10	Бичиг хэрэг	108.8	280.6	-171.8	147.9	147.9	0.0
11	Тээвэр, шатахуун	378.0	261.3	116.7	294.0	294.0	0.0
12	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	88.1	0.0	88.1	1,019.8	1,019.8	0.0
13	Ном хэвлэл	79.2	112.1	-32.9	107.5	107.5	0.0
14	Хог хаягдал зайлуулах	1,490.0	1,490.0	0.0	656.2	953.8	-297.6
15	Бага үнэтэй түргэн элэгдэх зардал	1,695.9	1,695.9	0.0	946.2	946.2	0.0
16	<b>Хангамж бараа материалын зардлын дүн</b>	<b>3,840.0</b>	<b>3,839.9</b>	<b>0.1</b>	<b>3,171.6</b>	<b>3,469.2</b>	<b>-297.6</b>
17	Эм, бэлдмэл	69.4	69.4	0.0	94.3	94.3	0.0
18	Хоол хүнс	38,683.6	18,562.1	20,121.5	30,283.8	20,543.8	9,740.0
19	Нормын хувцас,ЗЭ	6,530.2	6,530.2	0.0	5,992.4	5,992.2	0.2
20	<b>Нормативт зардлын дүн</b>	<b>45,283.2</b>	<b>25,161.7</b>	<b>20,121.5</b>	<b>36,370.5</b>	<b>26,630.3</b>	<b>9,740.2</b>
21	Багаж, техник, хэрэгсэл	4,050.0	4,050.0	0.0	7,100.0	7,100.0	0.0
22	Тавилга	4,000.0	4,000.0	0.0	0.0	0.0	0.0
23	Урсгал засвар	9,528.4	8,528.4	1,000.0	3,896.4	3,896.4	0.0
24	<b>Эд хогшил, урсгал засварын зардлын дүн</b>	<b>17,578.4</b>	<b>16,578.4</b>	<b>1,000.0</b>	<b>10,996.4</b>	<b>10,996.4</b>	<b>0.0</b>
25	<b>албан томилолт</b>	<b>111.1</b>	<b>110.0</b>	<b>1.1</b>	<b>151.1</b>	<b>151.1</b>	<b>0.0</b>
26	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	418.4	418.4	0.0	568.7	566.5	2.2
27	Аудит баталгаажуулалт	324.0	324.0	0.0	972.0	486.0	486.0
28	Мэдээлэл технологи	1,250.0	1,250.0	0.0	0.0	0.0	0.0
29	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ төлбөр, хураамжийн зардлын дүн</b>	<b>1,992.4</b>	<b>1,992.4</b>	<b>0.0</b>	<b>1,540.7</b>	<b>1,052.5</b>	<b>488.2</b>
30	Бараа үйлчилгээний	955.9	955.9	0.0	0.0	0.0	0.0
31	Хичээл үйлдвэрлэлийн	1,599.4	1,599.4	0.0	3,423.8	3,423.8	0.0

	дадлага хийх						
32	Бараа үйлчилгээний бусад зардал	2,555.3	2,555.3	0.0	3,423.8	3,423.8	0.0
33	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	31,588.8	-31,588.8	0.0	14,902.1	-14,902.1
	<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>389,131.0</b>	<b>381,254.0</b>	<b>7,877.0</b>	<b>428,367.9</b>	<b>417,206.2</b>	<b>11,161.8</b>

## 2.1. Орлого:

Төсвийн гүйцэтгэлийн судалгаанаас үзэхэд Цагааннуур сумын 2-р Цэцэрлэг нь 2020 оны төсвийн жилд нийтдээ 381254.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн, үүнд улсын төсвөөс 352835.4 мянган төгрөг санхүүжилт, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 28419.6 төгрөгийг тайланд бүрэн тусгаж зарцуулаагүй 31588.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2021 оны төсвийн жилд 417206.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн, үүнд улсын төсвөөс 390605.0 мянган төгрөг санхүүжилт, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 26303.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 297.6 мянган төгрөгийн орлогыг тайланд бүрэн тусгаж, зарцуулаагүй 14902.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Мөнгөн орлого дээр 2020 онд 2005296.8 мянган төгрөг, 2021 онд 6353.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө бараа материалын орлогыг хүлээн зөвшөөрч санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор тайлагнасан байна.

## 2.2. Төсвийн зарцуулалт:

Цагааннуур сумын 2-р Цэцэрлэг нь 2020 онд 349665.2 мянган төгрөг, 2021 онд 402304.1 мянган төгрөгийг батлагдсан төсвийн ангилалалаар зарцуулсан байна. Үүнд:

1. **Ажиллагсадтай холбогдсон зардал:** 2020 онд 248875.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 240296.5 мянган төгрөг зарцуулсан. Үүнээс нэмэгдэл цалинд 45187.7 мянган төгрөг, урамшуулалд 20430.6 мянган төгрөгийг зарцуулсан. 2021 онд 298307.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 293839.1 мянган төгрөг, нэмэгдэл цалинд 50802.1 мянган төгрөг батлагдсанаас 81441.3 мянган төгрөг зарцуулж 30639.2 мянган төгрөг дутагдсаныг үндсэн цалингаас шилжүүлж, урамшуулалд 20357.7 мянган төгрөг зарцуулсан байна. Жил бүр байгууллагын дарга ажилтантай холбогдох тушаал, цалин тогтоосон тушаал, урамшуулал олгох тушаал шийдвэрийг тухай бүр гаргасан нь хууль эрх зүйн үндэслэлтэй байна.

2. **Тогтмол зардал:** 2020 онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 35296.6 мянган төгрөг батлагдсанаас 28419.6 мянган төгрөг зарцуулсан үүнээс халаалтын зардалд 20292.6 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 4816.3 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 3310.6 мянган төгрөгийг зарцуулсан. 2021 онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 34585.9 мянган төгрөг батлагдсанаас 23126.6 мянган төгрөг зарцуулсан үүнээс халаалтын зардалд 11055.7 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 4748.6 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 7322.3 мянган төгрөг зарцуулсан баримт, нэхэмжлэх тооцоотой байна.

3. **Нормативт зардал:** 2020 онд эм, бэлдмэлийн зардалд 69.4 мянган төгрөг батлагдаж 69.4 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлд 6530.2 мянган төгрөг батлагдаж 6530.2 мянган төгрөг зарцуулсан, 2021 онд эм, бэлдмэлийн зардалд 94.3 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс 94.3 мянган төгрөг зарцуулсан, нормын хувцас зөөлөн эдлэлд 5992.4 мянган төгрөг батлагдсанаас 5992.4 мянган төгрөг зарцуулсан байна. Хүүхдийн хоолны зардалд 2020 онд 18562.0 мянган төгрөг, 2021 онд 20543.8 мянган төгрөг зарцуулсан байна.

*Хүүхдийн хоолны зарцуулалтыг материалын тайлангийн орлоготой тулган шалгахад:*

Сар	8-10 цагийн анги	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага-8-10цаг	Зорилтот бүлгийн хүүхдэд	Эцсийн үлдэгдэл	Норм
<b>2020 оны хүнсний материалын тайлан</b>							
1	623	0	3343475	1541925		1801550	2475
9	2842	1801550	5691680	7033950		459280	2475
10	3082	459280	7556570	7627950		387900	2475
11	923	387900	1970325	2284425	73800	0	2475
<b>Нийт</b>	<b>7470</b>		<b>18562050</b>	<b>18488250</b>	<b>73800</b>		
<b>2021 оны хүнсний материалын тайлан</b>							
3	2252	0	7473150	5573700		1899450	2475
9	1150	1899450	1680345	2846250		733545	2475
10	1566	733545	3216115	3875850		73810	2475
11	1664	73810	4253690	4118400		209100	2475
12	1540	209100	3920500	3811500		318100	2475
<b>Нийт</b>	<b>8172</b>		<b>20543800</b>	<b>20225700</b>	<b>0</b>		

2020 онд хүүхдийн хүнсний материалд 18562.1 мянган төгрөгийн худалдан авалт хийж 8-10 цагийн ангийн давхардсан тоогоор 7470 хүүхдэд 18488.3 мянган төгрөгийн хүнс зарцуулж 2021 онд хүүхдийн хүнсний материалд 20543.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж 8-10 цагийн ангийн давхардсан тоогоор 8172 хүүхдэд 20225.7 мянган төгрөгийн хүнс зарцуулж Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолоор баталсан "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 1. Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 төгрөг гэсэн заалтаар нормоор зарцуулсан, Хүнсний материалын үлдэгдэл 73.8 мянган төгрөгийн хүнсний материалыг 2-р цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар "Зорилтот бүлгийн хүүхдүүдэд хүнсний багц" тус тус зарцуулсан нь тайланд бүрэн тусгагджээ.

4. **Эд хогшил урсгал засварын зардал:** 2020 онд багаж, техник, хэрэгсэл худалдан авахад 4050.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 4000.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 8528.4 мянган төгрөг зарцуулсан. 2021 онд багаж, техник, хэрэгсэл худалдан авахад 7100.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 3896.4 мянган төгрөг зарцуулсан, хөрөнгийг орлогод бүртгэсэн байна.

Төсвийн зарцуулалтыг сар бүр батлагдсан хуваариын дагуу зарцуулж, тайлагнасан байна. 2022 оны эхний хагас жилд 316553.5 мянган төгрөгийн санхүүжилт, 1250.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого бүрдсэнийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.

### 2.3. Санхүүгийн байдлын талаар

#### Мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн харилцах данс, нэмэлт санхүүжилтийн дансанд 2020 онд 381254.0 мянган төгрөгийн гүйлгээ, 2021 онд 417206.2 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээ хийсэн баримтууд бүрэн байна. Харилцах дансны баримтад сар бүрийн дансны хуулга, төсвийн хэлбэлзлийн тайлан, сар бүрийн мэдээг хавсаргасан, тулгаж үзэхэд зөрүүгүй байна.

#### Үндсэн хөрөнгө

Цагааннуур сумын 2-р Цэцэрлэг нь 200 онд анх байгуулагдсан учраас үндсэн хөрөнгүүдийг бусад эх үүсвэрээр бүртгэж баланст тусгажээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 150 хүүхдийн хүчин чадал бүхий 1835544.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 64273.9 мянган төгрөгийн гал тогооны барилга, 3500.9 мянган төгрөгийн гадна хашааг "Эн Ди Констракшн" ХХК-тай 2018 оны 08 дугаар сарын 01-ны өдөр байгуулсан гэрээг 2019 оны 06 дугаар сарын 02-

ны өдөр гэрээг сунгаж 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр улсын комиссоос хүлээн авч ашиглалтад оруулах дүгнэлт гарч хөрөнгийг 2020 онд орлогод авч үйл ажиллагаа явуулах объектой болсон байна.

Тухайн жилд төсвийн хөрөнгөөр 7025.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном худалдан авсан, авсан, БШУЯ- 8370.0 мянган төгрөгийн хөргөгч, хөлдөөгч, 1,2-р хоолны тогоо, БСУГ-с 32.8 мянган төгрөгийн номыг үнэ төлбөргүйгээр өгснийг хүлээн авсан, Сумын ИТХТ-ийн 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 22 тоот тогтоолоор 1-р цэцэрлэгээс 44682.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил шилжүүлснийг бүртгэлд авсан байна.

2021 онд төсвийн хөрөнгөөр 6118.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 107.5 мянган төгрөгийн ном худалдан авсан, БСУГ-аас 2021 оны 02 дугаар сарын 18-нд 3044.0 мянган төгрөгийн зөөврийн болон суурин компьютер балансаас баланст шилжүүлснийг бүртгэлд авсан, 4194.0 мянган төгрөгийн 2097 м2 газрыг үнэлж бусад биет бус хөрөнгөнд орлогод авсан байна.

#### **Бараа материал**

Цагааннуур сумын 2-р Цэцэрлэг нь 2020 онд төсвийн хөрөнгөөр 43588.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1-р цэцэрлэгээс сумын ИТХ-ын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 22 тоот тогтоолыг үндэслэн шилжүүлсэн 12645.0 мянган төгрөгийн бараа материалыг аж ахуйн материал дансанд орлогоор авсан, тухайн жилд 38569.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан, жилийн эцэст 30991.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй.

2021 онд төсвийн хөрөнгөөр 46033.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БСУГ-аас 114.1 мянган төгрөгийн, эцэг эхийн хандиваар 3031.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 30.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, ДЗОУБ-с 164.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авсныг бүртгэсэн, 40164.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулан данс бүртгэлд тусгасан, 2021 оны жилийн эцэст 40005.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Өр, авлага:** 2020, 2021 онд өр, авлага үүсгээгүй, байгууллага хоорондын тооцоог дансаар хийж тооцсон байна.

**Анхан шатны бүртгэл хөтлөлт:** Бараа материалын орлого, зарлага, шаардах хуудас хөтөлсөн. Хөрөнгө орлогод бүртгэхдээ Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан үндсэн хөрөнгийн НХМаягт ҮХ-1, НХМаягт ҮХ-2, НХМаягт ҮХ-3 маягтыг бүрэн хөтөлсөн. Байгууллагын дарга тооллого хийх комисс томилж хөрөнгийн тооллого хийлгэн, комисс тайлан илтгэх хуудас бичиж ажилласан байна.

**Нягтлан бодох бүртгэл хөтлөлт:** Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журнал хэвлэсэн боловч мөнгөн хөрөнгийн, үндсэн хөрөнгийн журнал дэлгэрэнгүй бүртгэл хэвлээгүй.

**Санхүүгийн тайлан тэнцэл:** Санхүүгийн тайлангуудыг гаргаж аудитын байгууллагад хүргүүлж баталгаажуулсан байна. 2021 онд санхүүгийн тайлангийн бичмэл тодруулга тэмдэглэл бэлтгэсэн.

#### **2.4.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, ил тод байдал:**

Цагааннуур сумын 2-р Цэцэрлэгийн шилэн дансны мэдээлэл байршуулалтыг шалгахад

-2020 онд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан мэдээлээгүй, 2021, 2022 оны эхний хагас жилийн мэдээлэл байршуулалт хангалттай 100% байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны шинэчилсэн хувилбарыг нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагаа бүртгүүлсэн байна.

**Гурав. Санхүү бүртгэлийн үйл явц, шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал:**

Санхүүгийн хяналт шалгалтаар Цагааннуур сумын 2-р цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд төсвийг батлагдсан хуваарийн дагуу зориулалтаар нь зарцуулсан, өмч хөрөнгийг тухай бүр данс бүртгэлд авсан, санхүү төсвийн үйл ажиллагаанд ноцтой зөрчил дутагдал гараагүй боловч үйл ажиллагаатай хамааралтай дутагдлууд байна. Үүнд:

-Байгууллагын дарга төсвийн жилийн эхэнд бүтэц орон тоогоо батлаагүй

-Хөдөлмөрийн дотоод журам байхгүй, хамт олны хурал, байгууллагын даргын тушаалаар батлаагүй

-Нягтлан бодох бүртгэлийн журнал/ мөнгөн хөрөнгийн, үндсэн хөрөнгийн, өглөг авлагын журнал/ хэвлэж санхүүгийн тайлангийн иж бүрдлийг хангаагүй.

**Дөрөв. Байгууллагын төсөв, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт, дүгнэлт, арга хэмжээний санал:**

Цагааннуур сумын 2-р цэцэрлэгийн 2020 он, 2021 он, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалт, орлого бүрдүүлэлт, өмч хөрөнгийн ашиглалтын байдалд хийсэн хяналт шалгалтаар төсвийн хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв илэрхийлэн зориулалтын дагуу зарцуулсан, анхан шатны баримт материал эмх цэгцтэй, өмч хөрөнгөнд тавих хяналтыг хэрэгжүүлсэн, санхүүгийн зөрчилгүй байна гэж дүгнэлээ.

2-р Цэцэрлэг шинээр барьж байгуулагдсанаар 30 ажлын байр бий болсон 173 хүүхдийг сургаж сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэхэд томоохон ажил арга хэмжээ болсоныг тэмдэглэж байна.


**Тав.Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:**


Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид ажилдаа хэрэгжүүлэх талаар Цагааннуур сумын 2-р цэцэрлэгийн эрхлэгч З.СЭЛЭНГЭ-Д ЗӨВЛӨХ нь:

1. Төсвийн жилийн эхэнд бүтэц орон тоогоо батлах, хөдөлмөрийн дотоод журмыг тушаалаар баталгаажуулж мөрдөх
2. Нягтлан болох бүртгэлийн журналыг хэвлэж санхүүгийн тайлангийн мж бүрдлийг хангуулах

3. Шилэн дансны цахим хуудсанд 2020 онд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нөхөн мэдээлэх
4. Зөрчил дутагдлыг арилгаж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх


БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН  
МЭРГЭЖИЛТЭН  
ДОТООД АУДИТОР  Х.ОЮУНЧИМЭГ

ТАНИЛЦСАН:  
ЦАГААНУУР СУМЫН 2-Р ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ  3.СЭЛЭНГЭ  
НЯГТЛАН БОДОГЧ О.ОРХОНЧИМЭГ



ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА,  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Б.ДАРИХЖАВ

